



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

planetGOLD Монгол төсөл | 2022 оны 11-р сар

planetGOLD Монгол төлийн мэдээллийн товхимолтой танилцана уу

planetGOLD Монгол төв нь алтны бичил уурхайн салбарыг албажуулж, мэргэшүүлэх болон тус салбар дахь мөвг усны хэрэглээг бууруулахад хувьд нэмэр оруулахаар ажиллаж байна. Монгол Улсын төрийн байгууллагуудтай хамтрах замаар төлийн баг орон нутгийн хөжилд хувь нэмэр оруулдаг, өдр бүтээмжтэй, мөвг усны хэрэглээг халсан албан ёсны бичил уурхайн салбарыг бий болохоор ажиллаж байна. Цаашид төлийн талаарх мэдээллийг цаг тухайд нь тогтмол хүлээн авах хүсэлтэй бол бидний [Facebook](#) болон [Twitter](#) хуудсыг дагаарай.

Уулзалт



planetGOLD Монгол, Филиппин төлийн Удирдах Хорооны бүсийн хурал боллоо

2022 оны 9-р сар

9-р сарын 22-23-ны дрүүдэд Филиппин Улсын Манила хотод planetGOLD Монгол, Филиппин төлийн Удирдах хорооны бүсийн хоёрдугаар хурал зохион байгуулагдлаа. Тус бүсийн хурал нь төлийн ервхий явцын тайланг сонсож, туршлагаа хуваалцах боломжийг оролцогч талууд болон тэвчдд олголоо. Хуралд оролцсон тэвчид, хамтрагч талууд, төлийн багийнхан хоёр улсад хэрэгжиж буй төлүүдийн үйл ажиллагааны талаарх шинэхэн мэдээллийг хүлээж авч чадлаа. [Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын](#) дэд сайд Г.Түвдэндоржийн ахалсан Монгол Улсын тэвчид Филиппин Улсын айлчилсан бөд хурлын өнөтус улсын Камаринс Норте мужийн Паракале тосгонд хэрэгжиж буй төлийн үйл ажиллагаатай танилцлаа. Тэвчид planetGOLD Филиппин төлийн Удирдах хорооны гишүүдтэй хамт бичил уурхайн үйл ажиллагаатай танилцаж, 2023 оны эхээр ашиглалтад оруулахаар төвлж буй мөгв усгүй алт баяжуулах системийн бүтээн байгуулалттай танилцав.



planetGOLD Монгол төлийн менежер оролцогч талуудтай уулзлаа

2022 оны 9-р сар

planetGOLD Монгол төлийн менежерээр 2022 оны 7 сард томилогдсон Рене Рожер Тиссот Монгол Улсад зочилж, төлийн хамтрагч нар болох Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагуудтай уулзалт хийж, төлийн явцын талаар ярилцлаа. Түүнчлэн Сэлэнгэ аймгийн Мандал сум, Түнхэл тосгонд очиж орон нутгийн удирдлага, баяжуулах цех, бичил уурхайчидтай уулзаж мөгв усгүй алт баяжуулах технологийн суурилуулалт, хүдрийн нийлүүлэлт зэрэг асуудлуудаар ярилцаж, тодорхой шийдэлд хүрлээ.



Бичил уурхайн шинэ журмыг баталлаа

2022 оны 8-р сар

Монгол Улсын Засгийн газар 2022 оны 8 сарын 3-ны өдрийн 296 дугаар тогтоолоороо Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн баталлаа. Бичил уурхайн журмыг шинэчлэн боловсруулахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ахалсан ажлын хэсэг байгуулдсан бөгөөд тус ажлын хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ервхий газар, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Экологийн цагдаагийн алба, planetGOLD зэрэг олон оролцогч талууд орж ажилласан. Бичил уурхайн шинэ журам нь албан ёсны, мэргэжлийн, хариуцлагатай бичил уурхайг бий болгох ажлын эхлэл юм. Талуудын дараагийн гүйцэтгэх алхам бол шинэ журмыг Монголын бүх бичил уурхайчид болон орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудад сурталчлан ойлгуулж, үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм.

Сургалт



Бичил уурхайн жендэрийн зөвлөх нээлтээ хийлээ

2022 оны 9-р сар

Бичил уурхайчдын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан албан бус сүлжээ, ажлын баг болох Жендэрийн зөвлөх 2022 оны 9-р сарын 15-ны өдөр Сэлэнгэ аймгийн Мандал суманд нээлтээ хийлээ. Энэхүү зөвлөхийн хүрээнд бичил уурхайчид тулгамдаж буй асуудлаа

хэлэлцэх, шийдэл эрэлхийлэх, тодорхой сэдвээр чадавхжиж, жендэр, хүний эрхийн мэдрэмжтэй хариуцлагатай бичил уурхайн арга, туршлагыг түүчээлэх, түгээн дэлгэрүүлэх, хамтын эрх ашгийнхаа төвөгшөөх хөндлөнгийн асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Мандал сумын ИТХ-ын дарга Н.Эрдэнэцэцэг, planetGOLD Монгол төлийн Менежер Рожер Тиссо нар арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ жендэрийн талаар баримталж буй трийн бодлогуудыг салбарт хэрэгжүүлэх, бичил уурхай дахь эмэгтэйчүүдийн тэгш оролцоо болон жендэрийн эрх тэгш байдлыг хангахын чухлыг онцолж байв.

Нээлтийн семинарын үеэр зөлвийн гишүүд хамтран алсын хараа, зорилго, үнэт зүйл, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойлсны зэрэгцээ, түншлэл хамтын ажиллагааны чадвараа сайжруулав. Зөлвийн дараагийн үйл ажиллагаа 10-р сард явагдана.

“Бичил уурхайн ХАБЭА ба эрх зүйн орчин” сургалт зохион байгуулагдлаа

2022 оны 8, 9-р сар

planetGOLD төлө “Бичил уурхайн ХАБЭА ба Эрх зүйн орчин” сэдэвт сургалтыг сургалтыг 8, 9-р сард Говь-Алтай, Сэлэнгэ аймагт тус тус зохион байгуулав. Нийт 42 трийн албан хаагч (26 эмэгтэй, 16 эрэгтэй) тус сургалтанд оролцсон бөгөөд энэ удаагийн сургалтыг өнөө сургалтуудаас гарсан саналд үндэслэн хялбарчилж өрчилсв бөгөөд трийн албан хаагчдад илүү практик байдлаар хүргэв. Оролцогчид энэхүү сургалтаар алтны бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, ХАБЭА-шаардлагууд, бичил уурхай дахь эрсдэлүүд, түүнийг үнэлэх, химийн хорт бодисын нөөгтрийн болон бичил уурхайн байгууллагуудын хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын талаар нэгдмэл ойлголтыг авлаа. Бүлгийн ажлын үеэр оролцогчид бичил уурхайн салбарт тулгамдаж буй асуудлууд болох ХАБЭА-н асуудал хариуцсан трийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа дутмаг байдал; хууль бус алт олборлолт, мэдээллийн дутмаг байдлыг хөвдөж, цаашдаа аймаг, сумын түвшний ХАБЭА-н зөлвийн үүрэг, хариуцлагыг хэрхэн сайжруулах талаар хэлэлцэв.



Америкийн Монгол судлалын төвийн судлаачдад алтны бичил уурхайн салбарын тухай танилцуулав

2022 оны 7-р сар

planetGOLD Монгол төлийн менежер Б.Алтанбагана Америкийн Монгол судлалын төвийн зуны судалгааны судлаачидтай уулзаж planetGOLD төлийн үйл ажиллагаа болон алтны бичил уурхайн салбарын тухай дэлгэрэнгүй танилцуулга хийв. Танилцуулгын дараа асуулт хариултын хэсэг зохион байгуулж судлаачидтай бичил уурхайн албажуулалт, албажуулалтын ач холбогдол, алтны худалдааны сүлжээний талаар санал бодлоо солилцож сонирхолтой харилцан яриа өрнүүлэв.



[Даян дэлхийн байгаль орчны сан](#)-гийн санхүүжилтээр [НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр](#), [НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага](#) хамтран хэрэгжүүлж буй [planetGOLD Монгол](#) төлийг [Канад Улсын Алтны бичил уурхайн зөвлөл](#), [Байгаль орчин, аялал жуулчлалын яам](#) нар хамтран гүйцэтгэж байна.



Энэхүү мэдээллийн товхимлыг planetGOLD Монгол төслийн гол оролцогч талуудад илгээж байна. Хэрвээ та цаашид и-мэйл хүлээн авах хүсэлгүй бол доорх [unsubscribe](#) товч дээр дарна уу.

[Unsubscribe](#)